

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барилга угсралтын ажлыг Барилгын норм ба дүрэм /БНбаД/, Стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

Тендерийн бичиг баримтанд заавал бүрдүүлж ирэх материал:

- ❖ Барилгын засварын ажил гүйцэтгэх үе шатны график
- ❖ Талбайн зохион байгуулалтын зураглалыг заавал ирүүлнэ.

Бүх үе шатны ажлууд тухай бүрт нь хэмжилт хийж фото зургаар баталгаажуулах, зургийн авторын хяналтыг хийлгэсэн байна.

Барилгын засварын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ. БН ба Д-ийн зохих заалтуудыг баримтлан гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч Сүхбаатар аймгийн Уулбаян сумын 1-р багийн нутаг дэвсгэрт хийгдэх Ерөнхий боловсролын сургуулийн барилгын засварын ажлыг зураг, төсөл, төсвийн дагуу хийж гүйцэтгэнэ. Дээрхи ажлыг гүйцэтгэхдээ ажын зургийн дагуу хийж гүйцэтгэх стандартын дагуу хийж гүйцэтгэж ашиглалтанд оруулна.

Уулбаян сумын Ерөнхий боловсролын сургуулийн засварын ажилд:

1. Одоо байгаа дээврийг хуулж, шинээр хавтгай дээвэр хийх,
2. Хана, таазанд замаска хийж, эмульсэн будгаар будах,
3. Хэсэгчилсэн вакуман цонх угсрах,
4. Цоколд нөхөөс шавардлага хийж, эмульсэн будгаар будах,
5. Радиотор солих,
6. Аянга хамгаалалт, газардуулга угсрах зэрэг ажил хийхээр төлөвлөсөн байна.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

Монгол улсын Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх тохируулах хугацаа нэг жил байна”, 14.6-т “энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна” гэсэн заалтын дагуу баталгаа гаргаж өгнө.

Барилгын засварын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн ажилдаа хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц хэсэг өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад албан бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 28 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зургийн дагуу гүйцэтгэнэ.

Дээрхи техникийн тодорхойлолт заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагчид эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Х.ЭНХЦЭЦЭГ

